



2026 оны 8 дугаар сарын 12-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн намрын ээлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын Засгийн газраас Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөөг хангах, төрийн оролцоо, хүнд суртлыг бууруулах, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг дэмжих, өсөлтийн үр өгөөжийг иргэдэд хүртээмжтэй хуваарилах зорилгоор “Чөлөөлье” үндэсний санаачилгыг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2027 оны төсвийн төслийг Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн боловсрууллаа. Мөн эдийн засгийн эрх чөлөө, татвар, нийгмийн даатгал, ашигт малтмалын салбарт хэрэгжүүлэх хууль эрх зүйн шинэчлэлтэй төсвийн бодлого, арга хэмжээг нягт уялдуулсан болно.

Ирэх жилийн төсвийн бодлогыг иргэдийн бодит орлого, нийгмийн баталгааг хамгаалах, төрийн албан хаагчдын цалин, ахмад настны тэтгэврийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, төвлөрсөн зарим чиг үүргийг төсвийн хамт орон нутагт шилжүүлж, төвлөрлийг сааруулахад чиглүүлнэ. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, эрчим хүч, зам, логиستيкийн хүртээмжийг сайжруулж, төрийн бүтээмж, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэн, ипотекийн зээлийн хүртээмжийг өргөжүүлнэ. Төсвийн зарцуулалт бүрийг хэрэгцээ, бэлэн байдал, үр өгөөжөөр эрэмбэлж, улсын төсвийг хувийн хэвшил, орон нутаг, гадаад зээл, тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтыг татах хөшүүрэг болгон ашиглахын зэрэгцээ төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хадгална.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 2027 оны төсвийн жилд төвлөрүүлэх нийт орлого, зарцуулах хэмжээ, хөрөнгө ба өрийн удирдлага, улс болон орон нутгийн төсөв хоорондын татаас, шилжүүлэг болон бусад зохицуулалттай холбогдсон харилцааг тусгасан 4 бүлэг, 19 зүйл, 2 хавсралттай байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Монгол Улсын 2027 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө, өрийн удирдлага, Монгол Улсын төсөвт 2027 оны төсвийн жилд ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагчдын Монгол Улсын төсөвт 2027 онд эргэн төлөх төлбөр, 2027 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсөв, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгох санхүүжилт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зардлын хэмжээ, Төсвийн тогтворжуулалтын санд 2027 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, 2027 оны төсвийн жилд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх Засгийн газрын хийх гадаад, дотоод зээллэгийн дээд хэмжээ, Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээ, 2027 оны төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2027 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн

төлбөрийн хэмжээ, Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ, Засгийн газраас Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг”-т нийцүүлэн хэрэгжүүлэх өрийн зохицуулалтын үйл ажиллагааны талаар;

Гуравдугаар бүлэгт орон нутгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгийн талаар;

Дөрөвдүгээр бүлэгт төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2027 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, улсын төсвийн хөрөнгөөр 2027 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн болон суурь дэд бүтцийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2027 онд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ болон Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн хуваарилалт ба санхүүжилтийн эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн болон суурь дэд бүтцийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон Засгийн

газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай, Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай, Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---o0o---